

хийлээ. БНМАУ, БНХАУ-ын бүх талын харилцаа сүүлийн жилүүдэд хэлбэрэлтгүй сайжирч байгаа нь монгол, Хятадын ард түмний язгуур эрх ашигт, зүй ёсоор нийцэж байна.

Эцэст нь тэмдэглэхэд, дэлхий дахины байдалд эргэлтийн шинжтэй өөрчлөлт гарч, олон улсын харилцаанд улс төрийн шинэ сэтгэлгээ тууштай нэвтэрч буй өнөөгийн нөхцөлд бүрэн хэвийн болох зүгт эргэлт буцалтгүй чиглэсэн Монгол, Хятадын харилцаа нь урьд өмнөхөөсөө ялгаатай, шинэ маягийн харилцаа байх болно. Учир нь, найрсаг сайн харилцаатай байсан тэртээ 1950-иад он, эдүгээ үе хоёрын олон улсын харилцааны орчин нөхцөл, чиг хандлага, түүнчлэн тус хоёр орны нийгмийн хөгжил, эдийн засгийн чадавхи, дэлхийн тавцанд эзэлж буй байр суурь зэргийг орон зай, цаг хугацааны хувьд харьцуулан авч үзвэл нэн өөр болжээ.

Харин харилцааны өнө удаан жилийн уламжлал, олон талын туршлагатай хөрш зэргэлдээ манай социалист хоёр орны тухайд санал зөрөөтэй зарчмын асуудал байхгүй учраас найрамдал, харилцан туслах тухай 1960 оны гэрээний үзэл санааны дагуу энх тайвнаар зэрэгцэн орших зарчмын үндсэн дээр бүх талын харилцааг хөгжүүлэх өргөн боломж өнөө байна,

80-ААД ОНЫ ХЯТАД-АМЕРИКИЙН ХАРИЛЦАА (ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙН ТАЛААР)

О. Оюунгэрэл

Наяад оноос эхлэн БНХАУ-АНУ-ын харилцаа дэлхий дахины болон Ази, Номхон далайн бүс нутаг дахь улсуудын улс төрийн бодлого, хамтын ажиллагаа, түүний харилцаанд их нөлөө үзүүлж байна. Эдгээр хоёр улсын явуулж буй бодлого нь дэлхий дахинд нөлөө бүхий байр суурь эзэлдэгээс гадна нийгмийн өөр өөр байгуулалтай энэ улсуудын харилцааны онцлог шинж чанар нь ихэнхдээ тухайн үеийн олон улсын байдал, уур амьсгалаас хамаарч ирсэн билээ.

Гадаадын зарим хятад судлаачдын тэмдэглэснээр, маогийн бодлогын уршгаар Хятад орныг сүйрэлд хүргэсэн байдлаас аврах арга замыг Дэн Сяопин ба түүний талынхан сонгож авчээ. Хятадын удирдлага улс орныхоо эдийн засгийн гол гол салбарыг өрнөдийн хөрөнгө оруулалт, техник-технологийн мэргэжилтний тусламжтайгаар хөгжүүлэхийг голчлон зорьж байна. Наяад оны Хятадын технологийн

Өгүүллийн зүүлт

1. «Үнэн» 1949 10. 7.
2. «Үнэн», 1949, 10, -19,
3. «Жэньминь жибао» 1952. 10, 5.
4. «Үнэн». 1959, 9. 18
5. М. С. Капица, БНХАУ: гучин жилд гурван бодлого, .. - УБ: 1984, "207-р тал..."
6. Ж. Батмөнх, МАХН-ын XIX их хуралд тавьсан МАХН-ын Төв Хорооны тайлан, цаашдын зорилт. УБ., 1986, 14-р тал,
7. «Монголын мэдээ» сонин (хятад хэлээр) 1989, 7. 1.

импортын гол үндэс нь АНУ, Япон, Өрнөд Герман байгаа юм. 1981 — 1985 онд хятадын бүх технологийн импортын гэрээг дээрх 3 оронтой байгуулжээ. Эдгээрээс чухамхүү, АНУ нь богино хугацаанд Бээжингийн хувьд технологийн импортын хамгийн чухал түнш болов. Энэ хугацаанд Бээжин 1.225 млрд. долларын хэмжээнд технологийн салбарт хамтран ажиллах тухай 319 гэрээг АНУ-ын пүүсүүдтэй байгуулсан байна.

Америкаас уул уурхай, нефть хими, усан цахилгаан эрчим хүч геологи, төмөрлөг, шуудан, холбоо харилцаа болон электроникийн тоног төхөөрөмж авч байна.

1985 онд Хятад улс АНУ-аас 525 сая долларын хэмжээнд 95 нэр төрлийн технологийг «софтвэ» хэлбэрээр авчээ. Үүнд лицензи, технологийн үйлчилгээ, зөвлөлгөө, хамтарсан үйлдвэрийн гэрээ зэрэг орно.¹

Америк нь шинжлэх ухааны гол гол салбарт (цэргийн эдийн засгийг оролцуулан, технологийн давуу талтай гэж Бээжингийн удирдагчид үздэг учир 80-аад оны эхэн үеэс АНУ-тай харилцах харилцаанд гол анхаарлаа хандуулж ирэв. Тийм ч учраас 80-аад оны хятад-америкийн харилцааг улам ойртуулах явдалд эдийн засгийн хүчин зүйл чухал үүрэг гүйцэтгэх болов.

Хятадын ГЯЯ-ны сайд асан У Сюецянь 1988 оны 3-р сарын 9-нд «Нээлттэй бодлогыг баримтлан, дэлхийн энх тайвныг сахин хамгаалах» сэдвээр гадаадын сэтгүүлч, сурвалжлагчид оролцсон хэвлэлийн бага хурал дээр хятад-америкийн харилцааны талаар хэлэхдээ «хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоосноос хойш уг харилцаа нь үндсэндээ тогтвортой жигд хөгжиж байна. Хоёр орны удирдагчид дээд хэмжээний айлчлал хийж, худалдаа эдийн засгийн хамтын ажиллагаа нэлээд өсөн нэмэгдлээ» гэжээ.²

1979 оноос хойш гадаадын хөрөнгө оруулалтыг ихэсгэх гэсэн хятадын бодлогын үр дүнд 8 мянга гаруй хамтарсан үйлдвэр (үүнээс 304 нь америктай) хамтран байгуулав.

1987 он гэхэд Америкаас Хятадад оруулж буй хувь хүний хөрөнгө оруулалт 3 млрд 40 сая ам. доллар болж Хятад дахь гадаадын хөрөнгө оруулалтын 13,3 хувийг эзэлж, гадаадаас хятадад оруулж буй хөрөнгө оруулалтаар эхний байранд байв. Мөн онд Хятад нь америкийн 104 худалдаачнаас өөрийн оронд хөрөнгө оруулах төлөвлөгөөг баталжээ.³

1987 оны хятад-америкийн худалдааны нийт хэмжээ 8 млрд. орчим ам. долларт хүрч, 1979 оныхтой харьцуулбал 9 дахин өсөн нэмэгдсэн боловч гадаадын ялангуяа, америкийн худалдааны пүүсүүд БНХАУ-ын үйлдвэрийн бүтээгдэхүүний чанар хангалтгүй, ажиллах хүч, инженер-техникийн мэргэжилтний боловсролын түвшин доогуур зэрэг эдийн засгийн учир байдлаас гадна хууль зүйн олон шийдвэрлэгдээгүй асуудалтай тулгарав.

Хятадын засгийн газар өнгөрсөн жилүүдэд хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулахын тулд гадаадын хөрөнгө оруулагчдын сонирхлыг хамгаалах зорилгоор 50 гаруй хууль, тогтоомж боловсруулан гаргасан байна⁴. Гэвч тухайн хугацаанд хоёр орны хамтран байгуулсан олон арван үйлдвэр нь янз бүрийн асуудал, бэрхшээлтэй тулгарч, гадаад валютын дутагдал, мэргэжлийн боловсон дутагдах, хууль, тогтоомжуудад заагдсан татвар авах явдлыг жигд бус хэрэглэх, тухайн зах зээл рүү орох, эд материал олж авах явдал нь хязгаарлагдмал байгаа тухай АНУ-ын шүүх яамны сайд Эдвин Мэссе мэдэгджээ.

Тийм ч учраас, америкийн худалдааны корпорациуд БНХАУ-ын эдийн засагт үлэмж хэмжээний хөрөнгө оруулахаас болгоомжлох бо-

лов. Америкийн зарим үйлдвэрийн эзэд Хятадтай хамтарсан үйлдвэр байгуулахад ашиг орлоготой эсэхийг шалгах үүднээс хөрөнгө мөнгө технологийн хувьд зардал багатай түргэн борлогдох бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна.

Тухайлбал, АНУ-ын «Кока-кола ундааны компани» Хятадын зах зээлд их амжилт олж, улмаар худалдаагаа улам нэмэгдүүлэхийг эрмэлзэж байна.

Наяад оны эхээс уг компани нь Бээжин (1981), Гуаньжоу (1983), Фузянь мужийн Сямень (1984), Гуаньдун мужийн Жухай (1985) хотуудад 4 үйлдвэр байгуулсан нь эдийн засгийн хувьд ихээхэн ашигтай ажиллаж байна. 1985-1986 онд Гуаньжоу дахь үйлдвэр нь кока кола ундаа үйлдвэрлэж, 2,8 сая юаний орлого олжээ.⁵

ДЕС хэмээх АНУ дахь томоохон компьютерын үйлдвэрүүдийн нэг өөрийн салбар төвийг 1987 оны II хагаст Бээжинд барьж байгуулжээ. Түүний ерөнхийлөгч Р. Польсоны хэлснээр, уг төв нь орон нутгийн хүн амын доторхи бүх ажилгүйчүүдийн 98 хувийг ажлын байраар хангаж, өөрсдийн техникийн хүч чадлыг бүрэн дүүрэн ашиглаж Хятад дахь шинэчлэлтэд хувь нэмэр оруулахыг найдаж байна.⁶

Америкийн технологийг авч ашиглахын тулд БНХАУ-д валют санхүүгийн бэрхшээлээс гадна орчин үеийн үлэмж хэмжээний тоног төхөөрөмж худалдан авах бололцоо хязгаарлагдмал байна.

Хятадаас АНУ-д суугаа элчин сайд Хань Шу хятад-америкийн дипломат харилцаа тогтоосны 10 жилийн ойд зориулан сурвалжлагчдын асуултад хариулахдаа, «одоо хоёр орны эдийн засгийн харилцааны түвшинг хоёр орны хүн ам, байгалийн баялаг, зах зээл ба үйлдвэрлэлийн нийт түвшинтэй харьцуулбал сайн таарч зохицохгүй байна.

Хятадаас Америкт гаргаж буй экспорт нь америкийн импортын нийт хэмжээний 1 хувьд хүрэхгүй байна. Америкаас Хятадад оруулж буй хөрөнгө оруулалт Америкийн гадаадад оруулж буй хөрөнгө оруулалтын 0,3 хувьд хүрэхгүй байна» гэжээ.⁷

Өрнөдөөс авч байгаа техникийг угсарч ажиллуулахын тулд их хэмжээний хөрөнгө оруулалт шаардагдана. Гэтэл Хятадад улс ардын аж ахуйн шинэчлэлтэд дээрх хэмжээний шаардлага бүхий хөрөнгө оруулах бололцоо бага байна. Мөн түүнчлэн, орчин үеийн техникийг түргэн хугацаанд амжилттай угсарч ажиллуулах өндөр мэргэжлийн эрдэм шинжилгээний болон инженер-техникийн боловсон хүчин дутагдалтай байна. Эдгээр хүчин зүйлийг харгалзан, АНУ-ын нөлөө бүхий улс төрийн зүтгэлтэн эрдэмтэн нар БНХАУ-тай эдийн засгийн харилцааг хөгжүүлэх бодит бололцоог дүгнэж цэгнэхийг уриалж байна.

Жишээлбэл, АНУ-ын худалдааны төлөөлөгч БНХАУ-д айлчлаад 1988 оны 1 сарын 21-нд Вашингтонд америк-хятадын худалдааны талаар мэдэгдэл хийхдээ, «техникийн хөгжилгүйгээр ямар ч улс өндөр хэмжээний эдийн засгийн өрсөлдөөнд хамран оролцож чадахгүй билээ. Хятад улс нь орчин үеийн шинэ технологийг ашиглан өндөр үр ашиг бүхий үйлдвэрлэл хөгжүүлэх талаархи үйл ажиллагааг хурдан хэрэгжүүлэх тутам, хятадын экспортын хэмжээг ихэсгэн, ард түмнийхээ амьдралын түвшинг улам сайжруулах нөхцөлийг бүрдүүлэх болно» гэжээ.⁸

Шинэчлэлтийн программыг хэрэгжүүлэхийн тулд гадаадад нээлттэй бодлого явуулах, бүх оронтой худалдаа -эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн салбарт солилцоо, хамтын ажиллагаа хөгжүүлэх нь дэлхийд энх тайвныг сахин хамгаалах, дэвшилт хөгжлийн нэг чухал хүчин бөгөөд энэ нь дэлхийн энх тайвны үйл хэрэгт ч ашигтай, дэл-

хийн эдийн засгийн хөгжилд ч ашигтай⁹ гэж хятадын удирдлага үзэж байна.

Нөгөө талаар, хятадын улс ардын аж ахуйн шинэчлэлтийн нэг гол зорилго нь үндэсний батлан хамгаалалтыг шинэчлэх явдал бөгөөд иймээс ч Бээжингийнхэн гадаадаас цэргийн технологи авахыг ихээхэн сонирхож байна.

АНУ-ын зэвсэг хянах, зэвсэглэлийг хориглох агентлагийн мэдээлснээр, 1981 онд БНХАУ нь зэвсэг экспортлох талаар дэлхийд 10-р байранд орж байсан бол жилийн дараа 5-р байрыг эзлэх болжээ.¹⁰

Энэ мэдэгдлийг хийхдээ, АНУ юуны өмнө, зэвсэг, цэргийн техник технологи экспортлохдоо хууль зүйн хязгаар тогтоож, Бээжин-Вашингтоны харилцаанд Зөвлөлт хэрхэн хандаж буй, мөн Хятадын ардын чөлөөлөх армийн хүчин чадал, Ази, Номхон далайн бүс нутаг дахь Вашингтоны холбоотнуудын ашиг сонирхол зэрэг хүчин зүйлийг харгалзан үзсэн байна.

Хятадын удирдагчид, юуны өмнө, богино хугацаанд гадаад ертөнцтэй эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн харилцааг эрчимтэйгээр хөгжүүлэх замаар тус орныг хүчирхэг гүрэн болгон хувиргахыг эрмэлзэж байна. Үүний тулд тэд улс орныхоо шинэчлэлтийн программыг хэрэгжүүлэх үүднээс АНУ-ын хүсэл сонирхлын дагуу зохих зарим нөхцөлийг хангаж өгч, хариуд нь хэрэгцээт туслалцаа авахыг хичээж байна.

БНХАУ, АНУ хоёрын харилцаа хэвийн болсонтой адил, хоёр орны эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн салбар дахь хэлхээ холбооны хөгжил нь олон улсын байдлыг ерөнхийд нь сайжруулахад чиглэж байгаа бол энэ нь Ази, Номхон далайн бүс нутаг төдийгүй, хоёр орны болон даян дэлхийн ард түмний эрх ашигт нийцэх бөгөөд энх тайвныг сахин хамгаалахад ашигтай зүйл болно,

ХЯТАД-ЯПОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ХАРИЛЦААНЫ ӨНӨӨГИЙН ЗАРИМ АСУУДАЛ

Б. Сэржав

1980-аад оны эхээс эдийн засгийн нээлттэй бодлого баримталж ирснээс хойш Хятад улс эдийн засгийн тэнцвэртэй хөгжлийг хангах, гадаадын тэргүүний техник технологи олж авахад зориулж, гадаад бүх эх сурвалжаас улс ардын аж ахуйд 55 млрд. долларын хөрөнгийг оруулжээ. Энэ нь ч зохих үр ашгаа өгсөн юм.

1. «Исьюз энд стадиз». Тайбэй (Тайвань), 1988, № 2, хх. 92-94
2. «Жэньминь жибао» 1988, III. 11
3. «Синьхуа юебао», 1988. № 5
4. «Бэйжин ревью» 1987, IX, 7, х. 8—9
5. Мөн тэнд, 1983, П. 23, х. 29
6. «Бэйжин ревью» 1987. II. 16, х. 31
7. «Жэньминь жибар», 1988. XI, 28
8. «Жэньминь жибао», 1988. 1, 26.
9. Мөн тэнд. 1985. VII. 26
10. «Исьюз энд стадиз». Тайбэй (Тайвань). 1986. № 3, х. 16